Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тушаал “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Ерөнхий сайдын 2025 оны 12 сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгавар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай”
- Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ний өдрийн А/3 дугаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгж, ажилтангүй. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар дотоод аудитыг хийдэг бөгөөд тайлант хугацаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын Драммын Эрдмийн Театр нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын Драммын Эрдмийн Театрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 233,496.5 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                                   | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт           |
|--|--------------------|--------------------|--------------------|
| Б  | 1                  | 2                  | 3=2-1              |
| Авлага                                     | 400,000.0          | 236,712.0          | (163,288.0)        |
| Бараа материал                             | 1,233,920.7        | 1,403,075.9        | 169,155.3          |
| Үндсэн хөрөнгө                             | 7,114,663.8        | 6,875,300.1        | (239,363.7)        |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                  | <b>8,748,584.5</b> | <b>8,515,088.0</b> | <b>(233,496.5)</b> |
| Өр төлбөр                                  | 596.6              | 596.6              | -                  |
| Засгийн газрын хувь оролцоо                | 8,747,987.9        | 8,514,491.4        | (233,496.5)        |
| <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>8,748,584.5</b> | <b>8,515,088.0</b> | <b>(233,496.5)</b> |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Авлага дансны үлдэгдэл нь 236,712.0 мянган төгрөг болж 163,288.0 мянган төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлага буурсантай холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл нь 1,403,075.9 мянган төгрөг болж 169,155.3 мянган төгрөгөөр өссөн нь 435,701.1 мянган төгрөгийн материалыг худалдаж авч, 174,716.3 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулж, 9,441.2 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан, 82,388.4 мянган төгрөгийн хөрөнгийн ангилал шилжүүлж бүртгэсэн зэргээс шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 6,875,300.1 мянган төгрөг болж 239,363.7 мянган төгрөгөөр буурсан нь 140,863.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 28,516.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 91,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн авч, 78,198.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 24,900.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, тайлант хугацаанд 458,424.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой;
- Засгийн газрын хувь оролцооны дансны үлдэгдэл нь 8,514,491.4 мянган төгрөг болж, 233,496.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 7,753,098.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,261,128.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 95,841.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 17,024.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 191,051.9 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 39,299.3 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 561,966.5 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 578,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,663,298.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 4,132,444.7 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 273,415.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 4,405,860.0 мянган төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 4,388,331.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 4,386,976.8 мянган төгрөгийг зарцуулж, 1,354.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,386,976.8 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 18,719.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийг 10.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээс хуваарилсан зардлыг 153.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| /мянган төгрөгөөр/ |   |                    |                    |                 |             |
|--------------------|---|--------------------|--------------------|-----------------|-------------|
| Код                | Хөтөлбөр, арга хэмжээ                                 | Төлөвлөгөө         | Гүйцэтгэл          | Зөрүү           | Биелэлт     |
| <b>71702</b>       | <b>Соёл урлаг</b>                                     | <b>4,405,860.0</b> | <b>4,386,976.8</b> | <b>18,883.2</b> | <b>99.5</b> |
| 80101              | Үндсэн үйл ажиллагааны зардал                         | 3,862,434.0        | 3,843,715.0        | 18,719.0        | 99.5        |
| 80214              | Уран бүтээл хийлгэх                                   | 71,006.3           | 71,006.3           | -               | 100.0       |
| 80802              | Ажил олгогчоос олгох тэтгэмж                          | 30,718.5           | 30,708.1           | 10.4            | 99.9        |
| 81855              | Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт                       | 208,456.9          | 208,303.1          | 153.8           | 99.9        |
| 81569              | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх | 233,244.3          | 233,244.3          | -               | 100.0       |

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

**Биет бус хөрөнгө:** Театрын үйл ажиллагаатай холбоотой 2,978.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 программ хангамж, Ординат ХХК-аас худалдан авсан “Unicus” санхүүгийн программыг 2,800.0 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

**Унаа хоол:** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8, 61 дүгээр зүйлийн 61.1.10 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 8.4 дэх заалт, Захирлын 2025 оны А/32 тоот тушаалаар 20.0 мянган төгрөгөөр хоол, унааны хөнгөлөлтийг тогтоосон байна. Тайлант хугацаанд хоол унааны зардалд 522,344.9 мянган төгрөг төсөвлөж, 642,204.5 мянган төгрөгийг зарцуулж, 119,859.6 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.

**Бүтэц орон тоо:** Театрын бүтэц орон тоог 129 хүнээр анх баталсан боловч төсвийн тодотголоор 117 болж буурсан байна. Гүйцэтгэлээр 117 орон тоотой ажиллаж гүйцэтгэх албан тушаалын 7, үйлчилгээний албан тушаалын 5 хүнээр цомхотгосон байна.

Аудитаар дээрх зардлуудтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох өмнөх оны төвлөрүүлэх шилжүүлгийн буцаалтын орлогоос 400,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 787,844.3 мянган төгрөг, нийт 1,187,844.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс хангамж, бараа материалын зардалд 50,073.3 мянган төгрөг, нормативт зардалд 15,000.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 71,340.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 291,292.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 515,866.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 7,560.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 236,711.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улсын Драммын Эрдмийн Театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Улсын Драммын Эрдмийн Театр, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Азуре хүлүг аудит ХХК-ийн аудитын менежер Б.Өлзийхутаг, туслах аудитор Г.Нандин-Эрдэнэ, Г.Баасанбат нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер П.Болортуяа, гүйцэтгэх захирал Г.Мөнхбаяр нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Цэлмэгбаяр, аудитын менежер И.Эрдэнцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улсын Драммын Эрдмийн Театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,343,267.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 53,432.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилтийн хүрээнд түлш халаалт, цэвэр бохир усны зардлыг 32,004.8 мянган төгрөг, тээвэр шатахууны зардлыг 2,000.0 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэл, хөдөлмөр хамгааллын хэрэглэлийн худалдан авалт хийгээгүй, байгууллагын бүтэц орон тоог 129-өөс бууруулж, 117 болгож баталсан байна.

Тайлант хугацаанд 10 сая ба түүнээс дээш өртөг бүхий 111,972.9 мянган төгрөгийн номын сангийн тохижилт, засварын ажил, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт

байршуулах хүсэлтийг төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.2 "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлж, цахим дэлгүүрээс худалдан авалт хийж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 356,767.6 мянган төгрөгийн зөрчлөөс 244,767.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 111,972.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 29 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст байршуулбал зохих цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 6,814,602.5 мянган төгрөгийн 155 ажил гүйлгээ, 32 төрлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд иж бүрэн байршуулсан байна.

##### **4.4.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант хугацааны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулаагүй 122,199.0 мянган төгрөгийн урсгал засварын ажил, 122,568.6 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлаас аж ахуйн материал авах, барилгын дотоод засвар, тохижилтын ажил гүйцэтгүүлэх зэрэг худалдан авалтыг хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, 44.2-т “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна”, 44.3-т “Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ” гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.4.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын захирлын 2025 оны А/74 тоот “хамтын гэрээ болон хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үзүүлэх дэмжлэг тусламж” тушаалын үндэслэлд хүчин төгөлдөр бус Сангийн сайдын 2019 оны 74 тоот тушаалыг ашигласан, Хамтын гэрээний заалтыг тусгаагүй, ажилтнуудыг ямар шалгуур үзүүлэлтээр үнэлсэн нь тодорхойгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.6 “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн “19.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын захирал тушаал шийдвэр гаргахдаа хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг үндэслэж байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны II улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, цалингийн зардал, бараа материал дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 145,943.6 мянган төгрөгийн 8 алдааг залруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 3,813.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосныг барагдуулж, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй ажиллах 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн, байгууллагын эзэмшил газарт барилга бариулахтай холбоотой гэрээний асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн бөгөөд тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх шийдвэр аудитын хугацаанд ирээгүй байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт                        | Өмнөх аудитын үзүүлэлт |                | Биелэлт  |                |             |
|---------------------------------|------------------------|----------------|----------|----------------|-------------|
|                                 | Тоо                    | Дүн            | Тоо      | Дүн            | Хувь        |
| Акт                             | 2                      | 3,813.2        | 2        | 3,813.2        | 100.0       |
| Албан шаардлага                 | 1                      | -              | 1        | -              | 100.0       |
| Зөвлөмж                         | 2                      | -              | 2        | -              | 95.0        |
| Хуулийн байгууллагад шилжүүлсэн | 1                      | -              | 1        | -              | 90.0        |
| <b>Нийт дүн</b>                 | <b>6</b>               | <b>3,813.2</b> | <b>6</b> | <b>3,813.2</b> | <b>96.2</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарах шаардлагатай гэж шийдвэрлэлээ. Үүнд:

- Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын шинэчлэлийг санхүүгийн программдаа тусгасан байдал;
- Тус байгууллагад шинээр нэвтрүүлж буй цаг бүртгэлийн системд тулгуурлан цалингийн тооцооллыг хийсэн эсэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 157,726.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

### Залруулсан алдаа:

- Хандив тусламжаар хүлээн авсан 28,516.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй;
- Бараа материалын үлдэгдэлд хасах 814.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй аж ахуйн материал тайлагнасан;
- Бараа материалын бүртгэлд 78,756.9 мянган төгрөгийн 62 ширхэг үндсэн хөрөнгийн шинжтэй зүйлсийн дансны ангиллыг буруу бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг 325.0 мянган төгрөгийн дутуу тооцоолсон;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх элэгдлийн зардал нь үндсэн хөрөнгийн тодруулгын элэгдлийн зардлаас 4,414.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Ажилчдад өгөх 14,800.0 мянган төгрөг, хувь хүнд өгөх 18,250.0 мянган төгрөг, байгууллагад өгөх 11,000.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 602 дугаар тогтоолоор актласан 849.7 мянган төгрөгийн хөрөнгийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд засгийн газрын хувь оролцоог бууруулж нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр тайлагнасан байна.

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2 “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна”, УСНББОУС 3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, тооцооллын алдаа стандартын 42-т “...Тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухай санхүүгийн тайлан гарахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг” гэж тус тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 5,678.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, цаашид давтан гаргахгүй байх 5,678.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар илэрсэн 5,678.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 47,756.9 мянган төгрөгөөр бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

## 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-1. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үндсэн хөрөнгө, бараа материал, бусад хөрөнгийн хадгалалт хамгаалалт сайжруулах, ашиглалтын үр дүнг дээшлүүлэх талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээ болон дотоод хяналтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй бөгөөд үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 4 " Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1-д заасан өмч хамгаалах Байнгын зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, эсхүл түүний үүрэг биелүүлдэг менежерээр толгойлуулж ерөнхий ня-бо, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр захирлын шийдвэрээр байгуулна", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны А/65 дугаар тогтоолын хавсралт 2 дугаар хэсгийн 2.2.1 "Зөвлөл нь төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, хувийн хэрэг хөтлөх, улсын бүртгэлд бүртгүүлэх, хөрөнгийн тооллого хийх, санхүүгийн болон статистик мэдээ тайланг гаргах, холбогдох журмын дагуу тайлагнах ажлыг хариуцан ажиллана" гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Өгсөн зөвлөмж: Байгууллагад хандив тусламжаар хөрөнгө хүлээн авах, хөрөнгийн дотоод шилжилт хөдөлгөөн хийх бүрд хяналт тавьж, хуучирсан, эвдэрч гэмтсэн хөрөнгийг сайжруулах талаар арга хэмжээ авч, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах.

Илрүүлэлт-2. Байгууллагад бүртгэлтэй үндсэн хөрөнгө, бараа материалыг нийт хөрөнгө, бараа материалын үлдэгдэлтэй харьцуулан үнэн зөв тоолох гэрээг 2025 оны 12 сарын 01-ны өдөр ЭОС АИОН ХХК-тай гэрээ байгуулж 2,000.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1."Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 19 дүгээр зүйлийн "19.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно.", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл "Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн

тооллого, түүний хугацаа", 2. "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгө бараа материалын тооллогыг хууль тогтоомжид заасны дагуу үр дүнтэй зохион байгуулж дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хөрөнгийн тооллогыг бусад хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхгүй байх.

## **2. Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт-1. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж (210801) эдийн засгийн ангиллаас 3,675.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-д 210801 - Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж "Гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авахад төлөх энэ бүлэг (2108)-т зааснаас бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамжууд энд хамаарна" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангиллаас эдийн засгийн ангилал зөрчиж худалдан авалт хийхгүй байх, төсвийн зарлагын ангиллыг Сангийн сайдын баталсан журамд заасны дагуу хийж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Улсын Драмын Эрдмийн Театрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:**

| Алдааны товч утга  | Нийт алдаа |                  | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |                 | Буруу тусган илэрхийлсэн |                 | Үүнээс     |                  |              |     | Зөвлөмж |     |
|--|------------|------------------|-----------------------------------|-----------------|--------------------------|-----------------|------------|------------------|--------------|-----|---------|-----|
|  | Тоо        | Дүн              | Тоо                               | Дүн             | Тоо                      | Дүн             | Залруулсан |                  | Залруулаагүй |     | Тоо     | Дүн |
|  |            |                  |                                   |                 |                          |                 | Тоо        | Дүн              | Тоо          | Дүн |         |     |
| Бараа материалын үлдэгдэлд хасах 814.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй аж ахуйн материал тайлагнасан байна.   | 1          | 814.0            | -                                 | -               | 1                        | 814.0           | 1          | 814.0            | -            | -   | -       | -   |
| Бараа материалын бүртгэлд 78,756.9 мянган төгрөгийн 62 ширхэг үндсэн хөрөнгийн шинжтэй зүйлсийн дансны ангиллыг буруу бүртгэсэн байна.   | 1          | 78,756.9         | -                                 | -               | 1                        | 78,756.9        | 1          | 78,756.9         | -            | -   | -       | -   |
| Тайлант хугацаанд хандив тусламжаар хүлээн авсан 28,516.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй байна.   | 1          | 28,516.5         | 1                                 | 28,516.5        | -                        | -               | 1          | 28,516.5         | -            | -   | -       | -   |
| Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн элэгдлийн тооцоололд давтан тооцоолол хийж, горим хэрэгжүүлэхэд 5ш хөрөнгийн 325.0 мянган төгрөгийн элэгдлийг дутуу тооцоолсон байна.   | 1          | 325.0            | 1                                 | 325.0           | -                        | -               | 1          | 325.0            | -            | -   | -       | -   |
| Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх элэгдлийн зардал нь үндсэн хөрөнгийн тодруулгын элэгдлийн зардлаас 4,414.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.  | 1          | 4,414.4          | -                                 | -               | 1                        | 4,414.4         | 1          | 4,414.4          | -            | -   | -       | -   |
| Ажилчдад өгөх 14,800.0 мянган төгрөг, хувь хүнд өгөх 18,250.0 мянган төгрөг, байгууллагад өгөх 11,000.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.  | 1          | 44,050.0         | 1                                 | 44,050.0        | -                        | -               | 1          | 44,050.0         | -            | -   | -       | -   |
| Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 602 дугаар тогтоолоор акталсан 849.7 мянган төгрөгийн хөрөнгийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд засгийн газрын хувь оролцоог бууруулж нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр тайлагнасан байна. | 1          | 849.8            | -                                 | -               | 1                        | 849.8           | 1          | 849.8            | -            | -   | -       | -   |
| <b>Дүн</b>   | <b>7</b>   | <b>157,726.6</b> | <b>3</b>                          | <b>72,891.5</b> | <b>4</b>                 | <b>84,835.1</b> | <b>7</b>   | <b>157,726.6</b> | -            | -   | -       | -   |

Улсын Драммын Эрдмийн Театрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                | Үүнээс        |          |                 |          |          |                |                                      |                     |   |          |
|--|-------------|----------------|---------------|----------|-----------------|----------|----------|----------------|--------------------------------------|---------------------|---|----------|
|  |             |                | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |          | Зөвлөмж  |                | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|  | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн      | Тоо      | Дүн            | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн      |
| Байгууллагад бүртгэлтэй үндсэн хөрөнгө, бараа материалыг нийт хөрөнгө, бараа материалын үлдэгдэлтэй харьцуулан үнэн зөв тоолох гэрээг 2025 оны 12 сарын 01-ны өдөр ЭОС АИОН ХХК-тай гэрээ байгуулж 2,000.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.   | 1           | 2,000.0        | -             | -        | -               | -        | 1        | 2,000.0        | -                                    | -                   | -   | -        |
| Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үндсэн хөрөнгө, бараа материал, бусад хөрөнгийн хадгалалт хамгаалалт сайжруулах, ашиглалтын үр дүнг дээшлүүлэх талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээ болон дотоод хяналтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй бөгөөд үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. | 1           | -              | -             | -        | -               | -        | 1        | -              | -                                    | -                   | -   | -        |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж (210801) эдийн засгийн ангиллаас 3,675.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна.   | 1           | 3,675.8        | -             | -        | -               | -        | 1        | 3,675.8        | -                                    | -                   | -   | -        |
| <b>Дүн</b>   | <b>3</b>    | <b>5,675.8</b> | <b>-</b>      | <b>-</b> | <b>-</b>        | <b>-</b> | <b>3</b> | <b>5,675.8</b> | <b>-</b>                             | <b>-</b>            | <b>-</b>  | <b>-</b> |

Улсын Драммын Эрдмийн Театрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал:

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |                  | Үүнээс        |     |                 |                  |          |                  |                                      |     |   |     |
|---|-------------|------------------|---------------|-----|-----------------|------------------|----------|------------------|--------------------------------------|-----|---|-----|
|   |             |                  | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                  | Зөвлөмж  |                  | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|   | Тоо         | Дүн              | Тоо           | Дүн | Тоо             | Дүн              | Тоо      | Дүн              | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |
| <b>Төрийн хэмнэлтийн тухай хууль</b>  |             |                  |               |     |                 |                  |          |                  |                                      |     |   |     |
| Тайлант хугацаанд 10 сая ба түүнээс дээш өртөг бүхий 111,972.9 мянган төгрөгийн номын сангийн тохижилт, засварын ажил, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй байна.  | 1           | 111,972.9        | -             | -   | -               | -                | 1        | 111,972.9        | -                                    | -   | -   | -   |
| <b>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль</b>  |             |                  |               |     |                 |                  |          |                  |                                      |     |   |     |
| Тайлант хугацааны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулаагүй нийт 122,199.0 мянган төгрөгийн урсгал засварын ажил, 122,568.6 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлаас аж ахуйн материал авах, барилгын дотоод засвар, тохижилтын ажил гүйцэтгүүлэх зэрэг худалдан авалтыг хийсэн байна.  | 1           | 244,767.7        | -             | -   | 1               | 244,767.7        | -        | -                | -                                    | -   | -   | -   |
| <b>Бусад хууль тогтоомжийн хүрээнд</b>  |             |                  |               |     |                 |                  |          |                  |                                      |     |   |     |
| Тус байгууллагын захирлын 2025 оны А/74 тоот "хамтын гэрээ болон хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үзүүлэх дэмжлэг тусламж" тушаалын үндэслэлд хүчин төгөлдөр бус Сангийн сайдын 2019 оны 74 тоот тушаалыг ашигласан, Хамтын гэрээний заалтыг тусгаагүй, ажилтнуудыг ямар шалгуур үзүүлэлтээр үнэлсэн нь тодорхойгүй байна. | 1           | -                | -             | -   | -               | -                | 1        | -                | -                                    | -   | -   | -   |
| <b>Дүн</b>  | <b>3</b>    | <b>356,740.6</b> |               |     | <b>1</b>        | <b>244,767.7</b> | <b>2</b> | <b>111,972.9</b> |                                      |     |   |     |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 337/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/230/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын драмын эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацааны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулаагүй 122,199,090.00 (нэг зуун хорин хоёр сая нэг зуун ерэн есөн мянга ер) төгрөгийн урсгал засварын ажил, 122,568,556.00 (нэг зуун хорин хоёр сая таван зуун жаран найман мянга таван зуун тавин зургаа) төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардлаас аж ахуйн материал авах, барилгын дотоод засвар, тохижилтын ажил гүйцэтгүүлэх зэрэг худалдан авалтыг хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.2-т "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулдаггүй, төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулдаггүй, бараа үйлчилгээний бусад зардлаас аж ахуйн материал авах, барилгын дотоод засвар, тохижилтын ажил гүйцэтгүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын драмын эрдмийн театрын захирал (Н.Наранбаатар), ерөнхий нягтлан бодогч (Х.Цогзолмаа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Г.МӨНХБАЯР